



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/356

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Угтаалцайдам, Цээл сумдад хогийн олсны ургамал /каннабис/ устгах арга хэмжээг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрүүдэд 2 үе шаттай зохион байгуулахтай холбогдуулан шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 3,987,000 (гурван сая есөн зуун наян долоон мянган) төгрөгийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг аймгийн Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Б. Оюуншар.
Сонхирч.
+ Род.


Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 29 -ны өдрийн А/356 дугаар захирамжийн хавсралт

НЭР БҮХИЙ СУМДАД УРГАСАН ХОГИЙН УРГАМАЛ /КАННАБИС/ УСТГАХАД
ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /кг/	Нэгжийн үнэ	Нийт дүн
1.	Зингер /хор/	Кг	12.50	319,000	3,987,000
НИЙТ ДҮН			-		3,987,000

Тодруулга: Хор цацах траекторын ажлын хөлс ороогүй болно.

ХЯНАСАН:
СТСХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ч.ЦЭЦЭГСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
ХЭЗХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Г.ГАНБАЯР

